

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ
ОРШИХ ИХ ГАЛТЫН АДАГ ДЭЛЭНГИЙН
ДЭНЖИЙН АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН
ОРДЫН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-006612/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РИГЕСТРИЙН ДУГААР 5089417/

Хянасан:

БОАЖЯ-ны ахлах шинжээч _____/Б.Буяннэмэх/

Хэрэгжилтийг гаргасан:

Жотойн Бажууна ХХК-ийн уул уурхайн дарга _____Д.Осорням

Жотойн Бажууна ХХК-ийн геологич _____Л.Сэргэлэн

2022 он

ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	4
1.1. Уурхайн байршил, газарзүйн тогтоц.....	4
1.2. Цаг уур, уур амьсгал.....	4
1.3. Гадаргын усан сүлжээ, газрын доорх ус	5
1.4. Хөрсний төлөв байдал	5
1.5. Ургамлан нөмрөг.....	6
1.6. Амьтны аймаг.....	7
1.7. Геологийн тогтоц	7
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Уурхайн ашиглалтаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүд.....	8
2.1.1 Хөрсөн бүрхэвч	8
2.1.2 Агаар орчин	8
2.1.3 Усан орчин.....	8
2.2 Болзошгүй аюул, осол	8
2.2.1 Техникийн аюулгүй ажиллагаа	8
2.2.2 Гал	
түймэр.....	9
2.2.3 Аянга, цахилгаан	9
2.2.4 Үер.....	10
2.2.5 Газар хөдлөлт.....	10
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	10
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 10	
3.1.1 Агаар орчныг хамгаалах	10
3.1.2 Усан орчныг хамгаалах.....	10
3.1.3 Бусад хийгдсэн ажлууд	11
3.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	12
ДӨРӨВ. 2021 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	17

ОРШИЛ

Их галтын адаг Дэнжийн алтын үүсмэл орд нь Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 230 км зайд оршино.

Төсөл хэрэгжүүлэгч “Жотойн бажууна” ХХК нь Их галтын адаг Дэнжийн алтны шороон ордыг ашиглах MV-006612 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрлөөр олгогдсон нийт 47.83 га талбайтай.

Уурхайн олборлолтын ажлыг Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль болон холбогдох бусад хууль, журам, зааврын дагуу жил бүрийн “Уулын ажлын төлөвлөгөө” болон “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө” боловсруулан батлуулж түүний дагуу уулын ажил болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байна.

2022 онд тухайн үүсмэл ордыг ашиглах төслийн байгаль орчны нөлөөлөлийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г “ЭКО МАСТЕР” ХХК-иар хийлгэсэн бөгөөд дээрх үнэлгээнд заасан зөвлөмж болон төлөвлөгөө, хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 онд 1,5 га талбайд ашиглалт явуулж 11,1 мян.м³ элс угааж, 8кг 200,9 гр шлихээр (2022.10.27-ны өдрийн байдлаар) олборлосон.


“Жотойн бажууна” ХХК нь уул уурхайн зориулалтын тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон бөгөөд бульдозер Shantui SD-23, экскаватор Doosan 320, БНХАУ-д үйлдвэрлэсэн өөрөө буулгагч 2 машин болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна. Тайлант онд нийт 15 ажилтантай ажилласан.

Их галтын алтны шороон ордын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг үндэслэн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулав.

НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1. Уурхайн байршил, газарзүйн тогтоц

Их галтын адаг Дэнжийн алтны үүсмэл орд нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших бөгөөд Нийслэл Улаанбаатар хотоос зүүн урагш 230 км-т оршиж 170 км хатуу хучилттай замаар, 60 км шороон замаар холбогдоно. Төв аймгийн Заамар сум нь физик газарзүйн байрлалын хувьд Хэнтийн нурууны өмнөд хажуугаас салбарласан нам өндөрлөг уулс, тал хээрийн бүсийн ерөнхий шинж тэмдгийг хадгалсан хэсэгт далайн түвшнээс дээш 900-1100 м-ийн өндөрт оршино.



Зураг 1. Талбайн байршлын зураг

Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
Газрын солбилцол нь: М-48-137					
MV-006612 (47.3 га)	2007-02-22	30	1	104° 21' 40.93"	48° 15' 03.73"
			2	104° 21' 40.93"	48° 14' 33.82"
			3	104° 21' 11.45"	48° 14' 33.82"
			4	104° 21' 12.06"	48° 14' 47.94"
			5	104° 21' 13.93"	48° 14' 59.65"
			6	104° 21' 13.89"	48° 15' 02.41"
			7	104° 21' 16.65"	48° 15' 02.42"
			8	104° 21' 33.49"	48° 14' 57.42"

1.2 Цаг уур, уур амьсгал

Цаг агаарын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь +28 С байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1 сар ба агаарын хэм нь -37 С, хамгийн халуун сар нь 7 сар ба агаарын хэм +38 С хүрч дулаарна. Хоногийн ба температурын хэлбэлзэл багатай, хавар намрын улиралд баруун хойноос үргэлжилсэн салхи салхилна. Уулархаг нутгаараа хур тунадас ихтэй цас бороо их ордог. Өвлийн улиралд 10 сарын 25-аас эхлэн 10-25 см цасан бүрхүүл тогтож жилийн 4 сарын 15-аас эхлэн хайлна.

1.3 Гадаргын усан сүлжээ, газрын доорх ус

Угаах төхөөрөмжийн усны хэрэгцээг Туул голын гадаргуугийн усаар сэлбэх замаар эргэлтийн усан сан байгуулж ханган ажиллаж байна.

Хэрэгцээт усныхаа 70%-ийг эргэлтийн усаар, 30%-ийг цэвэр усаар сэлбэн хангаж, нуурын усны түвшинг барьж байхаар төлөвлөсөн.

1.4 Хөрсний төлөв байдал

MV-006612 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй талбай нь Төв аймгийн Заамар сумын нутгийн зүүн урд талд байрлалтай бөгөөд Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилийн Хар хүрэн ба хүрэн хөрсний дэд бүсэд хамаарагдана.

Алт олборлолт явагдаж байгаа газарт дараах хөрсүүд голлон тархсан байна. Үүнд:

Уулын хар хүрэн хөрс: Энэ хөрс уулархаг газраар голлон тогтворжсон байх бөгөөд хөрсний үржил шимийн түвшингээр дундаж хэмжээнд байх ба уулын хээрийн ургамлан нөмрөгтэй, гадаргын хэрчигдэл ихтэй, хайрга чулуу ихтэй байх тул бэлчээрийн эдэлбэрийн зориулалтаар байна.

Сайр чулуурхаг болон сайргархаг хар хүрэн хөрс /толгодын/: Энэ хөрс ашиглалтын талбайд нам уулс тэдгээрийн бэл хормойн хэсгээр болон толгодорхог гүвээрхэг гадаргаар тогтворжих бөгөөд үетэн, алаг өвс нилээд холилдсон хээрийн ургамалшил дор голлон тогтворжих бөгөөд тархалтын доод хил нь толгодын бэл хормойн буюу геоморфологийн хилээр голын хөндийн хөрснөөс тод зааглагдана.

Нугархаг хар хүрэн хөрс: Энэ хөрс уулс хоорондох голын хөндийн хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт нутгийн чийгсэг ургамал болох нугын ургамал бүхий үетэн, улалжилт бүлгэмдэл давамгайлах ба тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй.

Хар хүрэн хөрс: Энэ хөрс уулс хоорондох өргөн, нарийн хөндийн гүвээрхэг болон тэгшивтэр хэсгээр голлон тогтворжих бөгөөд ургамлан нөмрөгт тал хээрийн ургамал болох үетэн-алаг өвст бүлгэмдэл давамгайлах ба тухайн хөрс үржил шимийн түвшин өндөртэй байна.

Нугын хужирлаг хөрс: Энэ хөрс уулс хоорондох хөндийн дундах хотос хэсгээр тогтворжсон байх бөгөөд дэрс ба цахилдаг бүхий улалжилт ургамлын бүлгэмдэл давамгайлах бөгөөд хөрсний үржил шимээр төдийлэн сайнгүй байдаг.

1.5 Ургамлан нөмрөг

Энд ургамлан бүрхэвчийн хувьд 50-60% бүрхэцтэй, арви харьцангуй сийрэг ургамлан нөмрөгтэй. Мөн бусад ургамал-газарзүйн тойрогтой харьцуулбал зүйлийн бүрдлийн хувьд нийт 39 овог, 104 төрөлд хамаарах 175 зүйл ургамал бүртгэгдсэн байна.

Тус орд газар нь уурхайн ашиглалт явуулж эхлэхээс өмнө бэлчээрийн эдэлбэр байсан. Уурхай орчмын нутаг дэвсгэр нь ерөнхийдөө чулуурхаг хээрийн шинжийг илтгэсэн хялганат хээрийн бэлчээрийн хэв шинжтэй хааяа нэг шингэн дэрс энд тэнд ургасан байна.

1.6 Амьтны аймаг

Тус нутагт тал хээрийн амьтдаас зурам, оготно, хулгана, туулай, алаг даага зэрэг мэргэчид, үнэг, хярс, өмхий хүрэн зэрэг махчин амьтад элбэг тохиолдохоос гадна төрөл бүрийн жигүүртэн шувууд суурин ба нүүдлийн байдлаар амьдардаг.

1.7 Геологийн тогтоц

Уурхайн талбай нь геологийн тогтоцын хувьд Хойд Хэнтийн Баянголын гүний региональ хагарлын бүсэд байрлана. Талбайн баруун өмнөөс зүүн хойш чиглэсэн бүлэг хагарлууд нь Туул эртний гольдролыг дагасан Долооны хөндий ба Заамарын нурууг бүрдүүлэгч Заамарын нарст-антиклиналийг заагладаг. Баруун хойш бүлэг хагарлууд нь Туул голын хөндийн баруун цутгалуудын өргөн хөндийг үүсгэсэн талбайн блоклог тогтоцыг үүсгэнэ. Туул голын палео хөндийн эрчимтэй хөгжлийн тодорхой зүй тогтолтой өөрчлөлтийн дүнд сунасан бөгөөд дэнжүүдийн зэрэгцээ жижиг хэмжээний богино хавтгайдуу хэлбэрийн үлдцүүд хөгжсөн байна. Туул голын сав газрын геологийн тогтоц нь харьцангуй сайн судлагдаж түрүүчийн судлаачдын нарийвчилсан эрэл хайгуулын тайлан, материалууд хангалттай гарсан учир геологийн тогтоц, металлоген, ашигт малтмалын талаар товчлон бичсэн болно.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Уурхайн ашиглалтаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүд

2.1.1 Хөрсөн бүрхэвч

Уурхайн хөрс хуулалт, элс, хайрга тээвэрлэлт, овоолго зэрэг технологийн үйл ажиллагаа нь газрын хөрс, агаар орчин, гадаргын болон гүний ус, ордын нөөц, ургамал амьтны аймаг, оршин суугчдын эрүүл ахуй зэрэг байгаль орчны бүхий л тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдэг. Дэлэнгийн алтны уурхайн хувьд эдгээрээс хамгийн их нөлөөлөлд өртөж байгаа нь хөрсөн бүрхэвч, газрын хэвлий юм.

Дотоод овоолго хийх, уурхайн малталтанд өртсөн газарт нөхөн дүүргэлт хийж тэгшлэх, хэлбэршүүлэн засч хиймэл нуур байгуулах зэргээр эвдэрсэн газрыг нөхөн сэргээсэн.

2.1.2 Агаар орчин

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас агаар орчин бохирдохоос гадна уурхайн малталтанд өртсөн газар болон хөрсний овоолгын гадаргуугаас хийсэх тоос шороо орчны агаарыг бохирдуулдаг. Иймд уурхайн малталтанд өртсөн газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн.

2.1.3 Усан орчин

Уурхайн усан хангамжинд Туул голын гадаргуугийн усаар сэлбэх замаар эргэлтийн усан сан байгуулан ажиллаж байна.

Уурхайн ашиглалтын улмаас гадаргын усанд бараг нөлөөлөхгүй харин гүний усанд бага зэрэг нөлөөлөл үзүүлнэ. Иймд технологид хэрэглэсэн усаа шүүн тунгааж дахин ашигласаар ирсэн.

2.2 Болзошгүй аюул, осол

2.2.1 Техникийн аюулгүй ажиллагаа

Уул уурхайн үйлдвэрлэлд аюул, ослын талаар судалгаа, дүгнэлт хийж хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөл болон аваарь ослоос урьдчилан сэргийлэх талаар техник зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Иймд жил бүр аваарь устгах төлөвлөгөөг боловсруулан батлуулж дагаж мөрдөж байна.

Ажилчдын санамсар болгоомжгүй үйлдэл, техникийн бүрэн бус байдал зэргээс гадна байгалийн гэнэтийн аюул ослоос шалтгаалж уурхайд болзошгүй

аюул осол учирч болно. Иймд ашиглалт явуулахдаа Монгол улсад мөрдөгдөж буй хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хууль тогтоомж, дүрэм журам буюу “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Баяжуулах тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны нэгдсэн заавар”, “Үйлдвэр аж ахуйн байгууллагын галын аюулгүй ажиллагааны дүрэм”, “Үйлдвэрийн газрын аюулгүй ажиллагааны дүрэм” зэргийг өөрийн уурхайн онцлог байдалд тохируулан мөрдөхөөс гадна ажил мэргэжил тус бүрийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллалаа.

Үйлдвэрийн аваарь осол, саатал, гэмтэл бүр нь эдийн засгийн болон ажиллагсдын эрүүл мэнд, амь насанд хохирол учруулах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх аюултай. Иймд ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангаж ажилладаг. “Форум ланд” сургалтын төвтэй гэрээ байгуулан ажлын байрны аюулгүй ажиллагааны сургалтыг хамтран зохион байгуулсан болно.

Байгалийн гэнэтийн аюул осолд гал түймэр, аянга цахилгаан, үер усны аюул, газар хөдлөлт зэрэг ордог. Эдгээр нь хүний үйл ажиллагаанаас хамааралгүйгээр гэнэт учирч болох аюул учраас үүнээс урьдчилан сэргийлэх, тухайн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, анхны тусламж үзүүлэх талаар сургалт семинар зохион байгуулж ажиллаа.

2.2.2 Гал түймэр

Уурхайн ашиглалт явуулахдаа “Үйлдвэр аж ахуйн байгууллагын галын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллахаас гадна, хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд салхи, шуурга ихтэй үед ил задгай газарт гал гаргахаас болгоомжилж ажиллаа.

Иймд гал түймрээс урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг авч, гал түймрийг унтраах багаж хэрэгслээр бүрэн хангасан.

2.2.3 Аянга, цахилгаан

Зуны улиралд аянга цахилгаантай өдрүүдэд уурхайн техник хэрэгсэл, ажилчдын хөдөлмөрлөх нөхцөл түр саатаж улмаар аюул тохиолдох магадлалтай.

Иймд дуу цахилгаантай бороотой үед металл хийц бүхий тоног төхөөрөмж болон байгууламжаар дамжин ажиллагсад аянга цахилгааны осолд өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлээ. Шаардлагатай тохиолдолд уурхайн ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авч ажилласан болно.

2.2.4 Үер

Дэлэнгийн алтны үүсмэл шороон орд нь Баян амын хуурай сайруудыг дагаж ашиглалт явуулдаг тул үер усны нөлөөлөлд өртөх өндөр эрсдэлтэй юм.

Зун, намрын улиралд үргэлжилсэн их устай бороо орох нь уурхайн талбайд их хэмжээний үерийн ус хуримтлагдаж уурхайн үйл ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүйг анхаарч, суваг шуудуу татсан болно.

Иймд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор уурхайг тойруулан үерийн хамгаалалтын далан, шуудуу татсан бөгөөд үүнийг дахин сэргээлээ.

2.2.5 Газар хөдлөлт

Төв аймгийн Заамар сумын нутаг нь газар хөдлөлтийн 7 баллын бүсэд хамаардаг. Дэлэнгийн алтны үүсмэл шороон ордын ашиглалтанд “Жотойн бажууна” ХХК нь ажилчдын орон сууцны болон конторын барилгад вагончик, тохижуулсан контейнеруудыг ашиглаж байна. Эдгээр нь газар хөдлөлтийн үед аюул осол багатай.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

3.1.1 Агаар орчныг хамгаалах

Хуурайшилт ихтэй үед уурхайн ачиж буулгах талбай орчим болон уурхайн замыг 6 тн багтаамжтай усны сав бүхий чиргүүлээр зам дагуу авто машинаар чирж усалгааг хийж чийгшүүлдэг.

3.1.2 Усан орчныг хамгаалах

Тус компани нь ус ашиглалтын дүгнэлтийг “Монгол ус” ТӨҮГ-аар гаргуулан ус ашиглах зөвшөөрлийг сав газрын захиргаанаас авч, ус ашиглах гэрээ байгуулан ажиллав. Ус ашиглах дүгнэлтийн дагуу эргэлтийн сангаас эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор ус тогтоох нуурыг шинээр байгуулан хур бороо, цасны шар усыг цуглуулан хуримтлуулсан.




3.1.3 Бусад хийгдсэн ажлууд

- ✓ Уурхайн ажилчдын ажиллаж амьдрах нөхцлийг сайжруулах зорилгоор ажилчдын амрах байрыг шинэчлэн засварладаг.
- ✓ Мөн стандартын шаардлага хангасан ажилчдын өвөл, зуны нормын хувцасаар хангасан.



- ✓ Аюул осол гарч болзошгүй бүсийг урьдчилан тогтоож, хаалт хамгаалалтыг хийж, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээ, дохио санамжийг байршуулан ажиллаж байна.
- ✓ Ковид-19 цар тахалаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна. Ширээ, ажлын байр, хаалганы бариул, гар утас, ажлын объектыг ариутгалын бодисоор тогтмол арчиж арчлах соёлыг сурталчлан, түүнчлэн амралтын өрөө зэрэг нийтийн газруудыг тогтмол ариутгаж ажилчдынг халдвар хамгаалал, ариутгалын бодисоор хангаж байна.. Мөн тусгаарлалтын гэр барьсан.



Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

2022 онд 1,5 га талбайд уулын ажил явуулсан ба тухайн онд 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 3,8 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Биологийн нөхөн сэргээлт хийх талбайд шимт хөрсөө тарааж тэгшлэх, үр цацахад 9,230,000 төгрөг, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг хашаажуулахад 1,760,000 төгрөг, үр цацсан талбайд усалгаа хийхэд 5,555,000 төгрөг, мод тарихад 6,500,00 төгрөг нийт 23,041,000 төгрөг зарцуулсан.

Техникийн нөхөн сэргээлт

/Нөхөн сэргээхийн өмнө/




/ Нөхөн сэргээсний дараа/



Биологийн нөхөн сэргээлт



Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрсөөр хучиж, ургамлын үр цацаж, хавар хайлаас мод 2500 ширхэг, намар хайлаас мод 1000 ширхэгийг тариж усалгааг хийж байна.



3.2 Нүүлгэн шилжүүлэх , нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус уурхайн эдэлбэр газар болон тусгай зөвшөөрлийн талбайд өвөлжөө, хаваржаа байрладаггүй тул 2022 онд нүүлгэн шилжүүлэх ажил хийгдээгүй болно.

3.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Их галтын адаг Дэлэнгийн уурхайд одоогийн байдлаар түүх соёлын дурсгалт зүйл, археологи палентлогийн олдвор илрээгүй байна. Ашиглалтын явцад түүх соёлын олдвор байж болох үлдэгдэл илэрвэл олдворыг орон нутгийн байгаль орчны болон холбогдох газарт мэдэгдэж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.4 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Дээрх менежментийн хүрээнд байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах зорилгоор техникийн ашигласан хаягдал тос, тосолгооны бүтээгдхүүнийг “Нью-турбо сервис” ХХК-д улиралд нэг удаа гэрээний дагуу нийлүүлж хэвшүүлсэн.

3.5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

ЗДТГ-тай зөвшилцөж нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсаны үндсэн дээр уурхайн хотхон, цайны газраас үүсч буй ахуйн хог хаягдлыг Заамар сумын хогийн цэгт улиралд нэг удаа хаядаг.

3.6 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Тус уурхай нь Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториуд болох Гео-экологийн хүрээлэн, газарзүйн хүрээлэнгүүдэд ус, хөрсний дээжийг, цаг уурийн итгэмжлэгдсэн лабораторт агаарын шинжилгээг тус тус шинжлүүлж үр дүнгээс хамаарч тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Тухайлбал ажилчдын ундны усны хэрэгцээг Туулын гүүрний төвлөрсөн гүний усаар хангадаг. Уурхайн ажилчдын ХАБ, хөдөлмөр хамгааллын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бататгах зорилгоор цахим болон үйлдвэр дээрх сургалтыг тогтмол зохион байгуулж хэвшүүлсэн. Үүнд “Форум ланд “ ХХК-тай сүүлийн 5 жилийн хугацаанд гэрээний дагуу хамтран ажиллаж байна.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу бүх ажилчдаа Заамар сумын эмч нарын бүрэлдэхүүнээр жил бүр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулдаг.



3.7 Олон нийтэд тайлагнах хуваарь , төлөвлөгөөний биелэлт

Заамар сумын байгаль орчны байцаагчид улиралд нэг удаа тайлан мэдээг тогтмол өгдөг.


3.8 Биологийн олон янзын байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

ТӨВ АЙМГИЙН БОАЖГ-ын хувиарласан дагуу заамар сумын нутагт хууль бус гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж олон жил орхигдсон газраас 7га талбайд нөхөн сэргээлт хийсэн.

/Нөхөн сэргээхийн өмнө/




/ Нөхөн сэргээсний дараа/



3.9 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт







Компаний хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” Монгол улсын хуулийн дагуу ХАБАЭ-Н менежментийн систем, журмыг мөрдөж ажиллаж байна.


ХАБАЭ-н ажилтан Д.Осорням Л.Алтантуул нар өдөр бүр ажил эхлэхийн өмнө бүх ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгдөг. Мөн ХАБАЭ-н ажилтнуудыг оролцуулан хуваарь гаргаж, өдөр бүр үйлдвэрлэл явагдаж байгаа ажлын талбай дээр жижүүр хийж дотоод хяналтыг зохион байгуулж ажиллаж байна.

Батлав: "Жотойн Бажууна" ХХК-ний
Захираг:  Л.Сэргэлэн



"Жотойн Бажууна" ХХК-н 2022 онд хийх ажлын байранд хийн жүжүүрийн хуваарь

№	Жижүүр хийх албан тушаалтан	Жижүүр хийх өдөр/гараг/	Гарын үсэг
1	Урхайн дарга Д.Осорням	Даваа	
2	Механикч Л.Алтанхуяг	Мягмар	
3	Нярав Л.Алтантуяа	Лхагва	
4	Менежер П.Гантуяа	Пүрэв	
5	Механикч Л.Алтанхуяг	Баасан	
6	Нярав Л.Алтантуяа	Бямба	
7	Менежер П.Гантуяа	Ням	

Хуваарь гаргасан Уурхайн дарга  Д.Осорням

“ИЛ УУРХАЙН АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”-г боловсруулан холбогдох газраар батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан.

Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалтын паспортыг хөтлөж, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж, мэргэжлийн операторчдыг авч ажиллуулж, аюулгүй ашиглах дүрэм, журам, зааврыг мөрдөн ажиллаж байна.

Аюул осол гарч болзошгүй бүсийг урьдчилан тогтоож, хаалт хамгаалалтыг хийж, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээ, дохио санамжийг байршуулан ажиллаж байлаа.



Дэлэнгийн дэнжийн алтны шороон ордын 2022 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



**Дэлэнгийн дэнжийн алтны үүсмэл шороон ордын 2022 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Уурхайн талбайд болон бусад барилга байгууламж зэрэг газарт гал түймэр гарах тохиолдолд түүнийг хязгаарлах унтраах зорилгоор доор дурьдсан багаж хэрэгслийг шаардлага бүхий газруудад байршуулсан.

Үүнд: Багаж хэрэгслийн жагсаалт

№	Багаж хэрэгсэл	Хэмжих нэгж	Тоо
1	Дэгээ	ш	3
2	Лоом	ш	3
3	Шат	ш	2
4	Хөөсөн цэнэгтэй хор	ш	10
5	Төмөр хувин	ш	6
6	Хүрз	ш	6
7	Төмөр утас таслах багаж	Иж бүрдэл	2
8	Сүх	ш	3
9	Усны насос	ш	2
10	Элстэй сав	Тусгай сав	3
11	Устай сав	Тонн	5

2022 онд Их Галтын адаг Дэлэнгийн дэнжийн алтны үүсмэл шороон орд үйл ажиллагаагаа төлөвлөгөөний дагуу явуулж ил уурхайд осол, аварьгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэж дуусгасан болно.

**ДӨРӨВ. 2022 ОНЫ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
БИЕЛЭЛТ**

А. Хаягийн хэсэг

Байгууллагын нэр	“Жотойн бажууна”ХХК
Регистерийн дугаар	5089417
Ордын нэр	Их галтын Дэлэнгийн орд
Аймаг, нийслэл	Төв
Сум, дүүрэг	Заамар
Ашигт малтмалын төрөл	Алтны үүсмэл орд
Тусгай зөвшөөрлийн дугаар, талбай	6612А, 47.83 га
Олборлох, баяжуулах технологи	Ил аргаар, тээвэртэй ашиглалтын системээр олборлоно.
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн байгууллага	“ЭКО МАСТЕР”ХХК
Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийсэн он	2019 оны 6-р сарын 13

**Дэлэнгийн дэнжийн алтны шороон ордын 2022 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Б. Уул уурхайн нөхөн сэргээлт

Үзүүлэлт			Мөрийн дугаар	Хэмжих нэгж	Хэмжээ	
А			Б	В	1	
1. Олборлолт эхэлсэн он			1		2019	
2. Олборлолтод өртсөн талбай	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Олборлолтод өртсөн газар	Гүн	2	м	9,0
			Талбай	3	га	19,4
			Эзэлхүүн	4	мян.м ³	1099
		Гадаад овоолго	Гүн	5	м	-
			Талбай	6	га	-
			Эзэлхүүн	7	мян.м ³	-
		Бусад	Гүн	8	м	-
			Талбай	9	га	-
			Эзэлхүүн	10	мян.м ³	-
	Олборлолт явуулсан тайлант онд	Олборлолтод өртсөн газар	Гүн	11	м	9,0
			Талбай	12	га	2
			Эзэлхүүн	13	мян.м ³	79
		Гадаад овоолго	Гүн	14	м	-
			Талбай	15	га	-
			Эзэлхүүн	16	мян.м ³	-
		Бусад	Гүн	17	м	-
			Талбай	18	га	-
			Эзэлхүүн	19	мян.м ³	-
Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Олборлолтод өртсөн газар	Гүн	20	м	16	
		Талбай	21	га	1,5	
		Эзэлхүүн	22	мян.м ³	58,9	
	Гадаад овоолго	Өндөр	23	м	-	
		Талбай	24	га	-	
		Эзэлхүүн	25	мян.м ³	-	
	Бусад	Өндөр	26	м	-	
		Талбай	27	га	-	
		Эзэлхүүн	28	мян.м ³	-	
3. Техникийн нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	29	га	19,16
			Эзэлхүүн	30	мян.м ³	1030
		Гадаад овоолго	Талбай	31	га	-
			Эзэлхүүн	32	мян.м ³	-
		Бусад	Талбай	33	га	-
			Эзэлхүүн	34	мян.м ³	-
	Олборлолт явуулсан тайлант онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	35	га	3,97
			Эзэлхүүн	36	мян.м ³	262
		Гадаад овоолго	Талбай	37	га	-
			Эзэлхүүн	38	мян.м ³	-
		Бусад	Талбай	39	га	-
			Эзэлхүүн	40	мян.м ³	-
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	41	га	2
			Эзэлхүүн	42	мян.м ³	58,9
		Гадаад овоолго	Талбай	43	га	-
Эзэлхүүн			44	мян.м ³	-	
Бусад	Талбай	45	га	-		

**Дэлэнгийн дэнжийн алтны үүсмэл шороон ордын 2022 оны
байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

			Эзэлхүүн	46	мян.м ³	-	
4. Биологийн нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн дүнгээр	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	47	га	18,4	
		Гадаад овоолго	Талбай	48	га	-	
		Бусад	Талбай	49	га	-	
	Олборлолт явуулсан тайлант онд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	50	га	1,58	
		Гадаад овоолго	Талбай	51	га	-	
		Бусад	Талбай	52	га	-	
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	53	га	3,8	
		Гадаад овоолго	Талбай	54	га	-	
		Бусад	Талбай	55	га	-	
	5. Байршуулсан нөхөн сэргээлт	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн			56	сая.төг	15,2
		Олборлолт явуулсан тайлант онд			57	сая.төг	15,2
		Олборлолт явуулах төлөвлөгөөт онд			58	сая.төг	-
6. Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан	Олборлолт эхэлсэн үеэс, өссөн			59	сая.төг	211,7	
	Олборлолт явуулсан тайлант онд			60	сая.төг	14,7	
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд			61	сая.төг	22	
7. Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Хөрс хуулалт	Талбай	62	га	-		
		Хэмжээ	63	мян.м ³	-		
	Хүдэр олборлолт, элс угаалт	Талбай	64	га	1,5		
		Хэмжээ	65	мян.м ³	58,9		
	Бүтээгдэхүүн гаргалт		66	мян.тн			
		67	кг	2,16			
8. Олборлолтод ашиглагдах ус	Усны төрөл			68		Гадаргуу	
	Усны хэмжээ			69	мян.м ³	39,6	
9. Химийн хорт, аюултай бодисын зарцуулалт	Зөвшөөрөгдсөн хэмжээ			70	кг	-	
	Зарцуулсан хэмжээ			71	кг	-	
10. Олборлолтод өртсөн ойн бүрхэвч	Талбайн хэмжээ			72	кг	-	
	Мод			73	тоо	-	

Уурхайн дарга /Д.Осорням/